



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26-21-35,
Факс: (976-11) 32-21-27, E-mail: info@mfa.gov.mn,
<http://www.mfa.gov.mn>

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

2013. 10.30 № 09/6273
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

2013 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Цахим (биометрийн) дипломат паспорт эзэмшигчдийг виз авах шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр" 2013 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Энэ хэлэлцээрийн дагуу Монгол Улсын болон ХБНГУ-ын цахим дипломат паспорт эзэмшигч 6 сарын хугацаанд 90 хүртэл хоног, өөрөөр хэлбэл бүтэн жилд 180 хүртэл хоног тус тусын нутаг дэвсгэрт визгүй зорчих боломжтой юм.

Монгол Улсын дурдсан хэлэлцээрийн дагуу гагцхүү ХБНГУ-д визгүй зорчих эрхтэй бөгөөд Шенгений бүсийн бусад орны нутаг дэвсгэрт тухайн улсын, эсхүл Шенгений зохих визгүйгээр нэвтрэх эрхгүй юм. Харин Монгол Улстай харилцан визгүй зорчих хэлэлцээр байгуулсан Польш, Чех, Словак, Унгар улсад ХБНГУ-ын нутаг дэвсгэрээс /мөн эдгээр орны нутаг дэвсгэрээс ХБНГУ-руу/ шууд зорчих эрхтэй.

Энэхүү хэлэлцээрт хэрэглэгдэж буй "Цахим" буюу "биометрийн" гэсэн нэр томъёо нь Олон Улсын Иргэний Агаарын Тээврийн Байгууллагын олон улсын стандартын дагуу хүний биометрийн мэдээллийг хадгалах чадвар бүхий цахим санамжтай дипломат паспортод хамаарах бөгөөд тус яам 2012 оноос эхлэн энэ төрлийн дипломат паспортыг зохих албан тушаалтнуудад олгож байна.

Энэхүү хэлэлцээрийн дагуу ХБНГУ-ын цахим дипломат паспорт эзэмшигчид мөн 6 сарын хугацаанд 90 хүртэл хоног Монгол Улсад зорчих эрхтэй бөгөөд энэ нь 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй ХБНГУ-ын иргэдийг 30 хүртэл хоногийн хугацаанд Монгол Улсад визгүй зорчихыг зөвшөөрсөн Засгийн газрын шийдвэртэй хамааралгүй гэдгийг анхааралдаа авна уу. Өөрөөр хэлбэл цахим дипломат паспорт бүхий ХБНГУ-ын иргэн 30 хоногоос илүү хугацаагаар Монгол Улсад байх эрхтэй юм.

ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Б.МАНДАХБИЛЭГ



8000004281



Agreement
between
the Government of Mongolia
and
the Government of the Federal Republic of Germany
on
exemption from visa requirements for holders of diplomatic biometric
passports

The Government of Mongolia and the Government of the Federal Republic of Germany, hereinafter referred to as "the Parties",

desiring to intensify their bilateral relations,

considering their interest in strengthening their existing friendly relations and with a view to facilitating travel by nationals of the State of one Party to the territory of the State of the other Party,

have agreed as follows:

Article 1

This Agreement shall apply to holders of biometric diplomatic passports. The term "biometric" used in this Agreement refers to electronically enabled passports with biometric identification capability according to the international standards of the International Civil Aviation Organization (ICAO).

Article 2

Nationals of the State of one Party holding valid diplomatic biometric passports issued by a Party to this Agreement who are not posted or seconded to the territory of the State of the other Party shall be exempt from the visa requirement to enter, transit through, stay in and leave the territory of the State of the other Party up to 90 days (in one or several periods) within six months, beginning on the day of arrival (for nationals of Mongolia, the day of first entry into the Schengen Area). The present Agreement does not exempt nationals of Mongolia who are holders of the documents mentioned in Article 1 from visa requirements that may exist in the legislation of the remaining countries (apart from the Federal Republic of Germany) implementing the

Schengen Agreement. The exercise of paid activities, for which a work permit is required under the national legislation of the Parties, is not permitted.

Article 3

(1) This Agreement does not release members of diplomatic missions, consular posts as well as representatives of international organizations, located in the territory of the State of the other Party, holding valid diplomatic passports, as well as their family members, from the requirement to obtain a visa for accreditation by the receiving State prior to their arrival.

(2) The above mentioned persons may, following accreditation, enter, transit through, stay in and leave the territory of the receiving State without a visa during the period of their assignment.

(3) Nothing in this Agreement shall be construed as affecting the rights and obligations contained in the Vienna Convention on Diplomatic Relations of 18 April 1961 or the Vienna Convention on Consular Relations of 24 April 1963.

Article 4

The individuals mentioned in Articles 2 and 3 of this Agreement may enter or leave the territory of the State of the other Party at all border crossing points open to international passenger traffic.

Article 5

This Agreement shall not affect the obligation of the individuals referred to in Articles 2 and 3 above to observe the laws effective in the receiving State.

Article 6

This Agreement shall not affect the right of the competent authorities of either Party to refuse entry to or prohibit the stay of those persons declared undesirable or who fail to meet the conditions for entry and residence under national, European and international law.

Article 7

(1) In the event of the misuse of the rights deriving from this Agreement or for reasons of national security and public order each Party reserves the right to suspend, either in whole or in part, the implementation of this Agreement.

(2) The other Party shall be notified about the suspension of this Agreement through diplomatic channels, no later than 72 hours prior to the intended entry into force of such measure.

(3) The suspension of this Agreement shall not affect the rights of individuals mentioned in Articles 2 and 3 of this Agreement already residing in the territory of the State of the other Party.

Article 8

(1) The Parties shall exchange specimens of the diplomatic biometric passports through diplomatic channels not later than 30 days before the entry into force of this Agreement.

(2) Should the presently existing official biometric passports be modified or new official biometric passports be introduced by one Party, it shall convey to the other Party through diplomatic channels a specimen of this passport, no later than 30 days

before the date the new passport or modification enters into force. The Parties shall apply the standards and recommended practices for electronic machine-readable travel documents recommended by the International Civil Aviation Organization (ICAO).

- (3) The Parties shall notify the other Party of any changes in the national legislation regarding the issuance of official biometric passports no later than 30 days before the entry into force of the new regulations.
- (4) In the case of loss, theft or invalidity of an official biometric passport, the Parties shall notify each other without delay.
- (5) The Parties shall cooperate in the field of travel document security.

Article 9

The Parties may amend this Agreement by mutual consent through additional Protocols or exchanges of notes, according to the procedures mentioned in Article 11 paragraph 1 of this Agreement. These shall form integral parts of this Agreement.

Article 10

Any differences or disputes in the interpretation of the provisions of this Agreement shall be settled amicably by consultation or negotiation between the Parties through diplomatic channels.

Article 11

- (1) This Agreement shall enter into force one month from the date on which the Parties have informed each other – through diplomatic channels – that the national

requirements for such entry into force have been fulfilled and the specimen passports pursuant to Article 8 paragraph 1 have been transmitted. The relevant date shall be the day on which the last notification is received.

- (2) This Agreement shall be of indefinite duration. It may be terminated at any time in writing through diplomatic channels. It shall terminate three months after the receipt of such notification by the other Party.
- (3) Registration of this Agreement with the Secretariat of the United Nations, in accordance with Article 102 of the United Nations Charter, shall be initiated by Government of Mongolia immediately following its entry into force. The Government of the Federal Republic of Germany shall be informed of registration, and of the UN registration number, as soon as this has been confirmed by the Secretariat.

Done at Ulan Bator on May 8th 2013 in duplicate in the Mongolian, German and English languages, all three texts being authentic. In case of divergent interpretations of the Mongolian and German texts, the English text shall prevail.

For the Government
of Mongolia



For the Government of the Federal
Republic of Germany





ЦАХИМ (БИОМЕТРИЙН) ДИПЛОМАТ ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗ АВАХ ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман
Улсын Засгийн газар цаашид "Хэлэлцэн тохиролцогч Талууд" гэх,

хоёр талын харилцааг гүнзгийрүүлэхийг эрхэлэн,

хоёр улсын хоорондын найрсаг харилцааг бэхжүүлэхийг эрхэлэн,

Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд нөгөө улсын нутаг дэвсгэрт
зорчих нөхцлийг хөнгөвчлөхийг зорин,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн үйлчлэл цахим (биометрийн) дипломат паспорт
эзэмшигчдэд хамаарна. Энэхүү хэлэлцээрт хэрэглэгдэж буй "биометрийн"
гэсэн нэр томъёо нь Олон Улсын Иргэний Агаарын Тээврийн Байгууллага
(ICAO)-ын олон улсын стандартын дагуу биометрийн мэдээллийг хадгалах
чадавэр бүхий цахим санамжтай паспортод хамаарна.

2 дугаар зүйл

Нөгөө талын нутаг дэвсгэрт дипломат алба хашихаар томилогдон урт
болон богино хугацаанд ажиллахаас бусад тохиолдолд Хэлэлцэн
тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр цахим (биометрийн) дипломат
паспорт эзэмшигч иргэн, нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, дамжин
өнгөрөх, түр оршин суух, нутаг дэвсгэрээс нь гарах зэрэгт хүлээн авагч улсад
хүрэлцэн ирсэн эхний өдрөөс эхлэн (Монгол Улсын иргэдийн хувьд
Шенгений бүсэд орсон өдрөөс эхлэн) зургаан (6) сарын хугацаанд нийт ер
(90) хоног (хэсэглэн эсхүл бүхэлд нь) виз авах шаардлагаас чөлөөлөгдөнө.

Энэ хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан бичиг баримтыг эзэмшигч
Монгол Улсын иргэн Шенгений хэлэлцээрийн гишүүн бусад орнуудад
(Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас гадна) зорчих тохиолдолд виз
авах шаардлагаас энэхүү Хэлэлцээрийн дагуу чөлөөлөгдөхгүй.

Хэлэлцэн тохиролцогч Талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу
ажил, хөдөлмөр эрхлэхэд тухайн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл
шаардлагатай бол энэ хэлэлцээрийн дагуу зорчигч хоёр улсын иргэд ажил,
хөдөлмөр эрхлэхийг хориглоно.

3 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг улсын нутаг дэвсгэр дээр
оршин суугаа Дипломат төлөөлчийн газар, Консулын газар болон Олон
улсын байгууллагад томилогдон ажиллах нөгөө Талын хүчин төгөлдөр

дипломат паспорт эзэмшигч иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд нь хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө аккредитацийн виз авах үүргээс энэхүү хэлэлцээрээр чөлөөлөгдөхгүй.

2. Дээр дурдсан иргэд аккредитац авсны дараа томилолтоор ажиллах бүхий л хугацаанд хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, дажжин өнгөрөх, түр оршин суух, нутаг дэвсгэрээс гарах зэрэгт визгүй зорчиж болно.

3. Энэхүү хэлэлцээрийг 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц, 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцид заасан эрх, үүрэгт харьцисан утгаар тайлбарлаж үл болно.

4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн 2 болон 3 дугаар зүйлд дурдсан иргэд Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэр дэх олон улсын иргэний тээвэрт зориулсан хилийн боомтуудаар нэвтрэн орох, гарах эрхтэй.

5 дугаар зүйл

Дээрх 2 болон 3 дугаар зүйлд дурдсан иргэдийн хувьд хүлээн авагч улсын хууль тогтоомжийг даган биелүүлэх үүргийг энэхүү Хэлэлцээр хөндөхгүй.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагаас нэн тааламжгүй этгээд буюу *Persons non grata* гэж үзсэн, эсхүл дотоодын хууль тогтоомж, Европын холбооны, эсхүл Олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу тухайн улсад нэвтрэн орох, түр оршин суух иргэдэд тавигдах нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй тодорхой этгээдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах, түр оршин суухыг хориглох Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрхийг хөндөхгүй.

7 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу үүссэн эрхийг урвуулан ашигласан тохиолдолд болон үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журмын үүднээс Хэлэлцэн тохиролцогч Талууд хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох эрхтэй.

2. Хэлэлцээрийн үйлчлэлийг түр хугацаагаар зогсоох тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нэг Тал уг арга хэмжээ хүчин төгөлдөр болгохоос доод тал нь 72 цагийн өмнө нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

3. Хэлэлцээрийн үйлчлэлийг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ нь 2 болон 3 дугаар зүйлд дурдсан бөгөөд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт уг арга хэмжээнээс өмнө очсон этгээдийн эрхийг хөндөхгүй.

8 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрсдийн цахим (биометрийн) дипломат паспортны загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал өөрийн ашиглаж буй цахим (биометрийн) дипломат паспортод өөрчлөлт оруулах, эсхүл шинэ загварын цахим (биометрийн) дипломат паспорт олгох тохиолдолд тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болох, шинэ загварын паспорт нэвтрүүлэх өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө нөгөө Талдаа уг паспортны загварыг дипломат шугамаар хүргүүлнэ. Хэлэлцэн тохиролцогч Талууд Олон улсын иргэний загварын тээврийн байгууллага (ICAO)-с зөвлөмж болгосон цахим төхөөрөмжөөр уншигдах биометрийн мэдээллийг хадгалах чадвар бүхий цахим санамжтай зорчин явах бичиг баримтын стандарт болон аргачлалыг ашиглана.

3. Хэлэлцэн тохиролцогч Талууд цахим (биометрийн) дипломат паспорт олгох талаарх дотоодын хууль тогтоомжид орох өөрчлөлтийг нөгөө Талдаа шинэ журам хүчин төгөлдөр болох өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө мэдэгдэнэ.

4. Цахим (биометрийн) дипломат паспортыг үрэгдүүлсэн, хульгайд алдсан, эсхүл хүчингүй болсон тухай мэдээллийг Хэлэлцэн тохиролцогч Талууд нэн даруй харилцан солилцоно.

5. Хэлэлцэн тохиролцогч Талууд иргэний бичиг баримтыг үнэн зөв, баталгаатай байлгах чиглэлээр хамтран ажиллана.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрт өөрчлөлт оруулахаа харилцан тохиролцсоны дагуу нэмэлт протокол байгуулах, эсхүл 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ноот бичиг солилцоно. Ийнхүү оруулсан өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн заалтыг тайлбарлахад гарсан аливаа зөрүү, эсхүл маргааныг Хэлэлцэн тохиролцогч Талууд дипломат шугамаар зөвшилцөх буюу хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай мэдээллийг дипломат шугамаар харилцан солилцохын сацуу 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу паспортын загварыг хүргүүлснээс хойш нэг (1) сарын дараа хүчин төгөлдөр болно. Ингэхдээ сүүлчийн мэдээллийг хүлээн авсан өдрөөс тооцно.

2. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулав. Энэхүү хэлэлцээрийг дипломат шугамаар хүргүүлсэн мэдээллийн дагуу хэдийд ч цуцалж болно. Энэ тохиолдолд цуцлах мэдээллийг нөгөө Тал хүлээн авсан өдрөөс хойш гурван (3) сарын дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

3. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсон даруйд НҮБ-ын дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас бүртгэлийг баталгаажуулсан даруйд ХБНГУ-ын Засгийн газарт НҮБ-ын бүртгэлийн дугаарын хамт мэдэгдэнэ.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2013 оны 05 дугаар сарын 08-ны өдөр монгол, герман, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
ГЕРМАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

